



“Инновэйши
ИНВЕСТМЕНТ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 05/22 тоот тогтоолын
штц867 6183948 9024070240

1 дугаар хавсралтаар батлав.

“Инновэйши ИНВЕСТМЕНТ” ХК ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү “Инновэйши ИНВЕСТМЕНТ” ХК (цаашид “компани”гэх)-ийн Шүгэл үлээх бодлого (цаашид “Бодлого” гэх)-ийн зорилго нь шүгэл үлээх үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим, шүгэл үлээх процесс, зөрчил шалган шийдвэрлэх, шүгэл үлээгчийн мэдээллийг хамгаалах, урамшуулалт олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь үйл ажиллагаанд дотоодод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн засаглалын кодексыг мөрдөж ажиллана.

ХОЁР.БОДЛОГЫН ЗОРИЛТ

- 2.1. Бодлогын зорилт:
 - 2.1.1. хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;
 - 2.1.2. Хууль, дүрэм, журмын зөрчил, хууль бус үйлдэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, аливаа хууль бус үйлдлийн үр нөлөөд Компанид болон хувьцаа эзэмшигчид хохирол учруулахас хамгаалах;
 - 2.1.3. эрсдэлийн удирдлагыг сайжруулах;
 - 2.1.4. хяналтын тогтолцоог сайжруулах.

ГУРАВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО

- 3.1. Компани нь дотооддоо шүгэл үлээх соёлыг бий болгох зорилгоор дараах зарчмыг баримтална. Үнд:

 - 3.1.1. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль, СЗХ-ноос баталсан дүрэм журам болон эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох бусад дүрэм журмын хэрэгжилтийг хангах, дагаж мөрдөх биелүүлэх нь Компанийн ажилтан бүрийн үндсэн үүрэг байна.
 - 3.1.2. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн, ёс зүйгүй, шударга бус үйлдэл, байгууллагын болон ажилтнуудын ашиг сонирхлыг хүндэтгэж, аюулгүй байдлын эсрэг үйлдэлтэй тэмцэх нь ажилтан бүрийн үүрэг байна.

- 3.1.3. Компанийн ажилтан бүр зөрчлийг нэн даруй мэдэгдснээр байгууллага болон ажилтныг хамгаалах, зөрчлийг төслөн зогсоох, учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх эсхүл бууруулах ач холбогдолтой гэдгийг ухамсарлана.
- 3.1.4. Компани нь шүгэл үлээсэн ажилтныг ямар ч тохиолдолд хамгаалж, шүгэл үлээгчийн төлөөрх мэдээллийг чандлан нууцална.
- 3.1.5. Шүгэл үлээсэн ажилтны мэдээллээр байгууллагад учирч болзошгүй байсан эрсдэлийг бууруулсан, таслан зогсоосон, хууль эрх зүйн, санхүүгийн, нэр хүндийн болон аливаа эрсдэл гарахаас сэргийлсэн гэж үзсэн тохиолдолд шүгэл үлээж зөрчил мэдээлсэн ажилтны хувь нэмрийг цаг алдалгүй үнэлж, урамшуулна.
- 3.1.6. Компани нь зүй бус үйлдлийг нэн даруй хариуцлагатайгаар таслан зогсоож арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ ПРОЦЕСС

- 4.1. Компанийн аливаа ажилтан бүр Компанийн болон ажилтнуудын ашиг сонирхолыг хохироосон, хохироож болзошгүй бодит нөхцөл бүрдснийг олж мэдсэн, Компанийн дотоод дүрэм, журам, холбогдох хууль тогтоомж зөрчигдсэн, зөрчигдэж болзошгүй нөхцөл бүрдсэн, аль нэг ажилтан ёс зүйн зөрчил гаргасан, гаргахаар завдсан тохиолдлыг мэдсэн даруйдаа доорх сувгуудыг ашиглан Компанийн Ёс зүйн хороонд шүгэл үлээж мэдэгдэнэ. Үүнд:
 - Цахим хаяг:
 - Утас:
 - Биечлэн уулзах;
 - Бичгээр
- 4.2. Шүгэл үлээгч нь зөрчлийн талаар мэдээллэхдээ үнэн бодит үйлдэл, баримтын талаар мэдсэн, харсан зүйлээ мэдэгдэнэ.
- 4.3. Шүгэл үлээгч нь өөрийн мэдээлсэн зөрчлийг нотлох үүрэг хүлээхгүй боловч зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, үнэн зөвшийдвэр гаргаж цаашид авах арга хэмжээг цаг алдалгүй авахад туслах зорилгоор зөрчлийн талаарх нэмэлт мэдээлэл, нотлох баримтыг гаргаж өгч болно.
- 4.4. Шүгэл үлээгч нь энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээллэхдээ дараах зүйлийг дурьдсан байна. Үүнд:
 - Зөрчил гаргасан этгээдийн нэр, албан тушаал;
 - Шүгэл үлээх болсон нөхцөл байдал, үйлдлийн тайлбар;

- Шүгэл үлээгчийн холбоо барих мэдээлэл

ТАВ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ

- 5.1. Шүгэл үлээгчийн мэдээллийн дагуу зөрчлийг Ёс зүйн хороо, эрх бүхий алба тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу шаган шийдвэрлэнэ.
- 5.2. Шүгэл үлээгчийн мэдээллийн дагуу шалгахад зөрчил нь гэмт хэргийн шинжийг агуулж байвал Компани нь уг үйлдлийг нэн даруй хуулийн байгууллагад мэдээллэж, шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Ажилтан нь хууль бус үйлдлийг мэдсээр байж мэдээллэхгүй өнгөрөөсөн нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК

---oOo---

МУЛД
.РХОТ

ЙШН
ЧЕНТ

3902407024
МУЛД



ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр

Дугаар 05/22

Улаанбаатар хот

ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 9.6.17 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

- Инновэйшн Инвестмент ХК-ийн "Шүгэл үлээх бодлого"-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
- Батлагдсан болдогыг үйл ажиллагаандaa мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд, Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР

